1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,975,676.1
131103	ЗГНХ, ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,774,884.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	759,566.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	441,224.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Санхүү төрийн сангийн хэлтэс нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

СТСХ нь 7 орон тоотой ажиллаж байна. Санхүүгийн албаны дарга-1, төсвийн ерөнхий нягтлан бодогч-1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-3.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 51 төсвийн байгууллага, 12 орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж, 40 орон нутгийн тусгай сан, 19 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 төрийн бус байгууллага, нийт 123 байгууллагын санхүүгийн тайлан, замын сан, техник хяналт барьцаа, ОНЕО, ХО барьцаа, засаг дарга, орон нутгийн хөрөнгө оруулалт зэрэг 10 дансны гүйлгээ нэгтгэгджээ.

Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Аймгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хадгальж, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэн, байгаль орчин, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, бие даасан, оновчтой хөгжлийн загвар бүхий эдийн засагтай болоход оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлжээ.

2023 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд:

- Хүний хөгжил бүлгийн 22 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ
- Эдийн засаг бүлгийн 7 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ
- Засаглалын бодлого бүлгийн 7 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ
- Ногоон хөгжил байгаль орчин бүлгийн 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ
- КОВИД-19 бүлгийн 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ

Нийт 5 бодлого 42 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Жилийн эцсээр аймгийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг 94.1 хувиар үнэлж, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэжээ.

Өвөрхангай аймаг 2023 оныг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөжээ.

- Удирдлага зохион байгуулалт
- Малын гаралтай хүнсний түүхий эдийг нэмэгдүүлэх
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалт
- Хүнсний аюулгүй байдал гэсэн 5 чиглэлээр 42 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Зорилтот жилийн ажлын гүйцэтгэлийг Аймгийн ИТХ-аар хэлэлцэн, 94.4 хувиар үнэлжээ.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн “22.6.5.төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьялагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүngийн хамт батлах;

Мөн хуулийн 36.1.”Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

42.1. Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ.” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд оржээ.

Инфляцын сөрөг нөлөөллийг багасгаж, хүүхэд, ахмад настан, төрийн албан хаагчдын орлогын баталгааг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор жилийн дундуур төсвийг тодотгож, төрийн албан хаагчдын цалин хөлсний хэмжээ, зарим төрлийн нийгмийн халамж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тарифыг нэмэгдүүлсэн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журмыг баталж, 2023 оны 04 дүгээр сарын 15-аас Төрийн болон орон нутгийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хэрэгжүүлж эхэлсэн.

Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 65 дугаар тушаалаар “Аккруэл суурьт Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг 19 төсөвт байгууллагад 4 сумын Засаг даргын нөөц, 4 сумын ОНХСан, Нарны дөш Өрхийн эрүүл мэндийн төв, Засаг даргын А/500 дугаар захирамжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, Нийгмийн даатгалын хэлтэс, Төсвийн

ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 201 байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалт, ОНӨААТҮГазар 2, Арвайхээр, Тарарт, Богд, Баянгол, Зүүнбаян-Улаан, Бүрд сумдын ЗДТГ-т дотоод аудитыг хийж гүйцэтгэжээ. Үүнээс төлөвлөгөөт 31 хяналт шалгалт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 3, дотоод аудит 8 хийсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар нийт 2,625.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг засаж залруулах 444 заалт бүхий зөвлөмж, тухайн байгууллагад хөрөнгө орлого авах 851.6 сая төгрөг, төсвийг зориулалт бус зарцуулсан 6.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага, тухайн байгууллагад 14.8 сая төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 70.5 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх 1.2 сая төгрөгийн, нийт 86.5 сая төгрөгийн 27 акт тогтоожээ. Актын биелэлт 96.6 хувьтай, албан шаардлагын биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшилийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн дүн өмнөх оноос 276,552.8 сая төгрөг болж өмнөх оноос 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр өмч

/сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Дүнд эзлэх хувь Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	112,958.90	116,642.90	3,684.00	44.3	42.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	142,075.40	159,909.90	17,834.50	55.7	57.8
Нийт хөрөнгийн дүн	255,034.40	276,552.80	21,518.40	100.0	100.0
Нийт өр төлбөр	31,372.60	33,680.00	2,307.40	12.3	12.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	223,661.70	242,872.70	19,211.00	87.7	87.8
Ор төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	255,034.40	276,552.80	21,518.40	100.0	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө

Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өвөрхангай аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 19,246.7 сая, эцсийн үлдэгдэл 25,978.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,731.3 сая төгрөгөөр буюу 34.9 хувиар өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 20,879.7 сая буюу 80.4 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 5,098.3 сая буюу 19.6 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө			Төсөлт /+/- Бууралт/-/
				Арилжаан ы банк	Төрийн сангийн		
Кассад байгаа бэлэн мөнгө	23.9	22.1					(1.8)
Төгрөг	23.0	11.3	11.3				(11.7)
Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	0.9	10.8			10.8		9.9
Банканд байгаа бэлэн мөнгө	19,222.8	25,955.9					6,733.1
Төрийн сангийн харилцах	15,851.2	20,868.4				20,868.4	5,017.2
Арилжааны банк дахь харилцах	3,371.6	5,087.5			5,087.5		1,715.9
Нэмэлт санхүүжилтийн харилцах							
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	19,246.7	25,978.0	-	-	-	-	6,731.3
Үүнээс байгууллагын төрлөөр:							
Төрийн сан ОНЕО, н.с	9,072.3	11,285.7				11,285.7	2,213.4
ЭХСан	5,362.3	5,548.2				19.5	5,528.7
ОН-ын өмчтүүлдэгдлийн газар	3,355.1	5,087.7	11.3		5,076.4		1,732.6
Төсөл сан /ОНХО, Тех хяналт,	1,457.0	4,056.4				2.4	4,054.0
ДҮН	19,246.7	25,978.0	11.3	5,098.3	20,868.4		6,731.3

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн банканд үлдэгдлээр тайлгагнасан 20,868.4 сая төгрөгийн 11,285.7 сая төгрөг буюу 54.1 хувь нь аймаг сумдын ОНЕО болон нэмэлт санхүүжилтийн дансанд, 5,548.2 сая төгрөг буюу 26.5 хувь нь төсөвт байгууллагууд, ОНХСан, ХХСан, ЭХСангийн дансанд, 1,457.0 мянган төгрөг буюу 19.4 хувь нь ОНХО, Техник хяналт дансанд тус тус үлдэгдлээр байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл							Техник хяналт
	ОНХСан	ОНЕОрлого	ХХСан	ЭХСан	Нэмэлт сан-лт	ОНХО		
Өвөрхангай аймаг	384.6	947.6				190.6	2,823.0	1,231.1
Бурд	107.0	259.4	109.6	32.6				
Бат-Өлзий	244.6	1,045.6	50.6	325.0				
Баруунбаян-Улаан	81.7	111.0	47.2	1.3				
Баянгол	156.3	79.4	26.9	3.4				
Гучин-Ус	111.7	42.8	28.3	32.5				
Есөнзүйл	61.7	250.5	71.5	9.8				
Өлзийт	18.7	234.3	34.0	4.7				
Зүүнбаян-Улаан	8.5	129.7	69.3	20.9				
Хайрхандулаан	86.2	172.9	47.6	2.6	15.4			
Нарийнтээл	83.4	231.3	1.8	30.0				
Сант	247.9	168.0	99.4	32.6				
Тарагт	174.2	179.1	70.1	1				
Төгрөг	261.3	217.3		33.7				
Уянга	306.1	354.5	97.0	4.3				
Богд	365.8	261.3	57.5	5.3				
Хужирт	312.9	666.8	47.7	38.5				
Хархорин	204.3	1121.6	289.7	0.2				
Арвайхээр	278.5	4583.9	176.4	0.7				
Баян-Өндөр	64.7	22.1	21.3	44.1				
ДҮН	3,560.1	11,079.1	1,345.9	623.2	206.0	2,823.0	1,231.1	

Аудитын илрүүлэлт: Сумдын эрсдэлээс хамгаалах сангийн данснуудын нийт үлдэгдэл 623.3 сая төгрөг байгаа ба үлдэгдлийг сум тус бүрээр авч үзэвл, нийт 14 төрлийн жижиг сан, төсөл арга хэмжээний зориулалттай мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна. Эрсдэлээс хамгаалах сангаас зарцуулсан зардлууд нь Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, ОНХСангийн зарцуулалт, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалт, ГХУСАХ-ний зарцуулалтуудтай давхардаж байна. Мөн энэхүү мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг цаашид орон нутгийн тусгай сангийн үйл ажиллагааны зориулалтаар дангаар нь журамлан зарцуулах эрх зүйн үндэслэлгүй байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагаудад Мөнгөн хөрөнгийн тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт 321.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тухайлбал:

-Уян сэтгэл өрхийн эмнэлэг 3.9 сая төгрөгэг, Баян-Өндөр сумын ЗДТГ 2.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн тайлан гаргаагүй

-Эрсдэлээс хамгаалах сангаас Арвайхээр, Бат-Өлзий, Бүрд, сумдын ТТЗ нар 23.3 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан

-Баян-Өндөр, Бат-Өлзий, Нарийнтээл, Богд, Гучин-Ус, Хужирт, Арвайхээр сумдын ИТХ-д ГХУСАХ-ний зардлаас 19.2 сая төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй

-Есөнзүйл, Төгрөг, Хужирт, Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга сумдын ЗДТГ-т Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 110.4 сая төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй байна.

-Арвайхээр сумын ЗДТГ бараа үйлчилгээний бусад зардлаас 54.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан

-Есөнзүйл, Уянга, тарагт, Нарийнтээл сумын ЗДТГ-т Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 12.5 сая төгрөгийг журмын дагуу зарцуулаагүй

-Ихэнх сумдын ИТХ, ЗДТГ-т бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 43.5 сая төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй ... гэх мэт

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 10,601.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,415.7 сая төгрөг болж 1,814.1 сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 72.2 хувь буюу 8,967.4 сая төгрөгийг хувь хүмүүс болон байгууллагаас авах авлага, 21.5 хувь буюу 2,670.6 сая төгрөгийг дансны авлага голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 4: Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/- Бууралт/-/-	Хувь
Ажилчидтай холбогдсон авлага	50.5	54.1	3.6	0.4
Төлберт үйлчилгээний авлага	7.6	109.9	102.3	0.9
Татаас санхүүжилтийн авлага	18.0		(18.0)	
Зээлийн хүүгийн авлага	306.4	252.2	(54.2)	2.0
Дансны авлага	1,915.2	2,670.6	755.4	21.5
Татва, НДШ-ийн авлага	0.1	158.3	158.2	1.3
Бусад авлага	8,098.6	8,967.4	868.8	72.2
Зээлийн авлага	205.2	203.2	(2.0)	1.6
Дүн	10,601.6	12,415.7	1,814.1	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Төсөвт байгууллага	125.0	142.5	17.5	1.1
Тусгай сан	8,323.8	9,205.7	881.9	74.1
ОН-ын өмчт үйлдвэрийн газар	2,152.8	3,067.5	914.7	24.7
Дүн	10,601.6	12,415.7	1,814.1	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын дансны бүртгэлийг насхилтаар ангилж харуулбал: Нийт авлагын 64 хувь буюу 7,951.7 сая төгрөгийн үлдэгдэл нь 5-аас дээш жилийн насхилттай, мөн нийт авлагын 10.4 хувь буюу 1,286.8 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн гэсэн ангиллаар нэгтгэгдсэн байна.

Өвөрхангай аймгийн төсвийн өрөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 5. Авлагын наслжилт

/сая төгрөг/

Ангилал	Ажилчид- тай холбогд- сон авлага	Төлбөрт үйлчилгээ- ний авлага	Дансны авлага	Байгуул- лаац авах авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Зээлийн хүүгийн авлага	Зээлийн авлага	татвар, НДШ авлага	Нийт	Эзлэх хувь
Эц.Үлд 0-1жил	1.8	69.6		189.6	1675	27.4	68.5		2,031.9	16.4
Эц.Үлд 1-2жил	0.2	34.9	1.0	164.9	1056.3	28.3	122.8		1,408.4	11.3
Эц.Үлд 2-3жил	0.2	34.9			620.3	4.7	12		672.1	5.4
Эц.Үлд 3-4жил	0.2	34.9			130.6	2.6			168.3	1.4
Эц.Үлд 4-5жил	0.2	34.9			142.6	5.6			183.3	1.5
Эц.Үлд 5-аас дээшжил	51.6	58.9	2,669.6	207.2	4780.8	183.6		158.3	7,951.7	64.0
Дүн	54.2	268.1	2,670.6	561.7	8,405.6	252.2	203.3	158.3	12,415.7	100.0
Үүнээс хугацаа хэтэрсэн ангилаар										
0-1 жил	0.2	34.9		15.0	313	4			367.1	28.5
1-2 жил	0.2	34.9			467.8	2.5			505.4	39.3
2-3 жил	0.2	34.9			198.6				233.7	18.2
3-4 жил	0.2	34.9			38.8				73.9	5.7
4-5 жил	0.2	34.9			6.9	2.3			44.3	3.4
5-аас дээшжил	0.2	34.9			27.3				62.4	4.8
Дүн	1.2	209.4	-	15.0	1,052.4	8.8	-	-	1,286.8	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчтэй хуулийн этгээдүүд тайлант онд үүссэн болон 5-аас бага жилийн наслжилттай авлагын наслжилтыг буруу бүртгэсэн, нягтлан бодогч нар э-тайланд авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байгаад хяналт тавиагүй байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад авлага бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг барагдуулаагүй зэрэг нийт **83.1** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тухайлбал:

-Есөнзүйл сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд **3.2** сая төгрөгийн өвс тэжээлийн авлагыг бүртгээгүй

-Нарийнтээл, Уянга сумдын ЗДТГ **3.5** сая төгрөг, Онги-Ус суураг ОНӨААТҮГ **6.7** сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй

-Өв-Эко мийт ОНӨААТҮГ нь **69.6** сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл **3,871.0** сая төгрөг болж, өмнөх оноос **2,242.3** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/ Бууралт /-/	Хувь
Урьдчилж гарсан зардал	1,627.0	3,871.0	2,244.0	100.0
Цалингийн урьдчилгаа	1.7	-	(1.7)	-
Дүн	1,628.7	3,871.0	2,242.3	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Төсөвт байгууллага	70.3	190.8	120.5	4.9
Тусгай сан	166.9	299.7	132.8	7.7
ОН-ын өмчтэй үйлдвэрийн газар	1,391.5	3,380.5	1,989.0	87.3
Дүн	1,628.7	3,871.0	2,242.3	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардлын **87.3** хувь буюу **3,380.5** сая төгрөг нь Баянтээг ХК-ийн нүүрсний нөөц өсгөх чанарын судалгааны ажлын зардлыг бүртгэсэн нь гол нөлөөг үзүүлжээ.

Мөн Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Тарагт Хайрхандулаан, Уянга сумдын ОНХСангаас зарцуулсан дуусаагүй ажлын 299.7 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 53,802.8 сая төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэл 45,844.8 сая төгрөг болж, 14.8 хувиар буюу 7,958.0 сая төгрөгөөр буурсан, нөөцийн барааны эхний үлдэгдэл 210.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 81.3 сая төгрөг болж 128.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Бараа материалын төрөл	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/ Бууралт/-/	Хувь
Тусгай зориулалттай материал	188.3	259.0	70.7	0.6
Эм боох материал	56.6	59.1	2.5	0.1
Дуусаагүй үйлдвэрлэл	49,951.0	41,358.6	(8,592.4)	90.1
Бэлэн бүтээгдэхүүн	68.7	69.3	0.6	0.2
Бичиг хэргийн материал	57.1	74.3	17.2	0.2
Аж ахуйн материал	1,454.3	1,630.8	176.5	3.6
Сэлбэг хэрэгсэл	417.0	728.7	311.7	1.6
Түлш шатах тослох материал	220.2	178.0	(42.2)	0.4
Барилгын засварын материал	228.5	185.2	(43.3)	0.4
Хүнсний материал	1.5	0.7	(0.8)	0.0
Бусад хангамжийн материал	1,052.4	1,182.0	129.6	2.6
Биологийн хөрөнгө	0.4	0.4	-	0.0
Мал амьтад	106.8	118.7	11.9	0.3
Бараа материалын дүн	53,802.8	45,844.8	(7,958.0)	99.8
Нөөцийн бараа	210.2	81.3	(128.9)	0.2
Нийт дүн	54,013.0	45,926.1	(8,086.9)	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 7,958.0 сая төгрөгөөр буурсан байгаа нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа дуусаагүй ажлуудыг ЗДТГ-ын дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэнээс тайлант онд дууссан барилга байгууламжийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, 8,592.4 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Харин нөөцийн бараа дансанд тэжээлийн нөөц 57.9 сая төгрөг /Бат-Өлзий, Гучин-Ус, Есөнзүйл, Тарагт, Уянга, Богд, Хархорин сумд/, буудайн нөөц 23.4 сая төгрөг /Хархорин сумын ЗДТГ/-ийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт. ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн Ахмадын сан нь нөөцийн бараа дансанд 10.3 сая төгрөгийн аж ахуйн материал бүртгэсэн байсныг аудитын явцад запруулж бүртгүүлэв.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад бараа материалыг тоолоогүй, зарцуулалтын анхан шатны баримт дутуу, тайлан гаргаагүй, бүртгэлд тусгаагүй зэрэг нийт **499.8** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тухайлбал:

-Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Хархорин сумдын ЭХСанд 65.5 сая төгрөгийн өвс тэжээлийг бүртгэлд тусгаагүй

-Хархорин-Ус суваг 380.5 сая төгрөг,, Өлзийт сумын ЗДТГ 2.1 сая төгрөг, Сант сумын ИТХ 7.4 сая төгрөгийн бараа материалд эд хариуцагчийн тайлан гаргаагүй

-Гучин-Ус сумын ЗДТГ 4.5 сая төгрөг, Аймгийн ИТХ 9.0 сая төгрөг, Өв-Эко мийт ОНӨААТҮГ 28.6 сая төгрөгийн бараа материалаа тоолж баталгаажуулаагүй байна.

-Баянтээг түлиши ОНӨААТҮГ, Бат-Өлзий сумын тохижилт үйлчилгээ, Хужирт эрдэс баялаг ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд 2.1 сая төгрөгийн бараа материал зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй...гэх мэт

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 28,452.0 сая төгрөг болж, өмнөх оноос 983.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/ Бууралт/-/
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	27,468.9	28,452.0	983.10
Дүн	27468.9	28452	983.1

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388, МОН-2301 төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн төв, Хужирт сумын төвд хэрэгжсэн төвийн цэвэрлэх байгууламжийг бүртгэжээ. Энэ онд 983.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төслийн хөрөнгийг бий болгох явцад тайлант онд нэмэгдсэн зардал нь хөрөнгийн өртөг дээр нэмэгдэж байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 159,909.9 сая төгрөг болж, өмнөх оноос 17,834.5 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 95.3 хувийг биет хөрөнгө, 4.7 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үндсэн хөрөнгийн ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/ Бууралт/-/	Хувь
Газар	31.7		-31.7	-
Барилга байгууламж, орон сууц	86,930.1	97,913.8	10,983.7	61.2
Тээврийн хэрэгсэл	6,816.6	6,749.9	(66.7)	4.2
Машин тоног төхөөрөмж	6,693.9	6,166.2	(527.7)	3.9
Тавилга эд хогшил	1,038.0	989.5	(48.5)	0.6
Зам гүүрийн брилга байгууламж	17,570.5	17,953.2	382.7	11.2
Түүх соёл музейн дурсгалт зүйлс	30.4	30.4	-	0.0
Бусад үндсэн хөрөнгө	15,274.1	21,937.5	6,663.4	13.7
Дуусаагүй барилга байгууламж	587.9	636.7	48.8	0.4
Ном	5.5	18.1	12.6	0.0
Биет хөрөнгийн дүн	134,978.7	152,395.3	17,416.6	95.3
Программ хангамж	129.6	140.4	10.8	0.1
Бусад биет бус хөрөнгө	6,155.5	6,126.3	(29.2)	3.8
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	811.6	811.6	-	0.5
Бусад эргэлтийн бус хөрөнгө		436.3	436.3	0.3
Биет бус хөрөнгийн дүн	7,096.7	7,514.6	417.9	4.7
Дүн	142,075.4	159,909.9	17,834.5	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийн данс гол нөлөөг үзүүлжээ. Барилга байгууламж Хархорин сумын ЗДТГ-т 4,043.1 сая төгрөгөөр, Арвайхээр сумын ЗДТГ-т 2,077.5 сая төгрөгөөр, Онги-Ус суваг ОНӨААТҮГ-т 3,079.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад үндсэн хөрөнгө Хужирт сумын ЗДТГ-т 5,673.8 сая төгрөгөөр, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-т 355.6 сая төгрөгөөр тус тус өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдэхэд тус тус нөлөөлсөн байна.

ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн төсөвт болон төрийн өмчийн аж ахуй нэгж байгууллагууд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХСангийн хөрөнгө, болон өөрийн хөрөнгөөр нийт 31,545.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгажээ. Үүний 2,282.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 29,262.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй болон бусад эх үүсвэрээр бэлтгэжээ.

Аудитын илрүүлэлт: "Баянтээг түлш" ОНӨҮГ нь эзэмших эрхтэй 31.7 сая төгрөгийн өртөг бухий газраа Бусад биет бус хөрөнгө дансанд бүртгээгүй Газар дансанд тусдаа бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын зөрчлийн нэгтгэлээр үндсэн хөрөнгө данстай холбоотой 3,840.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тухайлбал:
- Үндсэн хөрөнгийн тайлагналтай холбоотой 1,013.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Тухайлбал: Өв-Эко мийт ОНӨААТҮГ нь 3,769.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөө жилийн эцсээр тоолж баталгаажуулаагүй, Баянтээг ХК нь 70.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зөрчлүүд байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 33,680.0 сая төгрөг болж, өмнөх оноос 2,307.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Өр төлбөрийн ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт I+I Бууралт/-I	Хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	14.8	41.8	27	0.95
Бараа үйлчилгээний зардлын өглөг	16.8	17.6	0.8	0.4
Татаас санхүүжилтийн өглөг	602.1	602.1	-	13.7
Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг	41.9	27.3	(14.6)	0.6
Байгууллагад төлөх өглөг	998.5	1,012.6	14.1	23.0
Хувь хүмүүст төлөх өглөг	169.1	69.3	(99.8)	1.6
Татварын өглөг	313.5	587.8	274.3	13.3
НДШ-ийн өглөг	9.1	1.0	(8.1)	0.0
Ноогдол ашигийн өглөг	4.0		(4.0)	-
Дансны өглөг	962.6	2,044.3	1,081.7	46.4
Богино хугацаат өр төлбөр	3,132.4	4,403.8	1,271.4	100.0
Төрийн өмчийн аж ахуй нэгжийн зээл	771.4	771.4	-	2.6
Олон улсын санхүүгийн байгууллагад төлөх	27,468.9	28,504.8	1,035.9	97.4
Үрт хугацаат өр төлбөр	28,240.3	29,276.2	1,035.9	100.0
Нийт	31,372.7	33,680.0	2,307.3	107.4
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	708.1	672.5	(35.6)	15.3
Тусгай сан	387.1	439.9	52.8	10.0
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	2,037.2	3,291.4	1,254.2	74.7
Богино хугацаат өр төлбөр	3,132.4	4,403.8	1,271.4	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	27,468.9	28,504.8	1,035.9	97.4
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	771.4	771.4	-	2.6
Үрт хугацаат өр төлбөр	28,240.3	29,276.2	1,035.9	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр

Нийт богино хугацаат өр төлбөрийн 46.4 хувь буюу 2,044.6 сая төгрөг нь Баянтээг ХК, ӨВ-Эко мийт, Баянтээг түлш ОНӨААТҮГ-ын дансны өглөг байна.

Байгууллагад төлөх өглөг 23 хувийг эзэлж байна. Үүнд Бурд, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга сумдын ОНХСанд 337.5 сая төгрөгийн өглөг бүртгэжээ. Арвайхээр TYK-д 10.3 сая төгрөг, ӨВ-Агро ОНӨААТҮГ-т 186.8 сая төгрөг, ӨВ-Эко мийт ОНӨҮГ-т 430.2 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг бүртгэлтэй байна. Мөн Уянга сумын Жаргалантын ЕБС, Хархорин сумын 1 дүгээр сургуульд орон нутгийн төсвөөс олгох 19.9 сая төгрөгийг өглөгөөр тайлагнажээ.

Үрт хугацаат өр төлбөр

Дамжуулан зээлийн оны эхний үлдэгдэл 27,468.9 сая төгрөг байсан. МОН-2301 төслийн зээлд Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвөөс хуваарийн дагуу

Өвөрхангай аймгийн төсвийн өрөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1,333.3 сая төгрөг төлж, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 789,2 сая төгрөгийг зээлийн төлбөрт суутган нийт 2,122.5 сая төгрөг төлсөн. МОН-3388 төслийн ажил 2023 онд дуусаж хүлээлгэн өгсөн. Хүлээлгэн өгөхөөс өмнөх хугацааны ашиглалтын зардал 1,922.3 сая төгрөг гарч, нийт өглөгт нэмэгдсэн. Хүүгийн төлбөрт төлсөн дүн зээлийн үлдэгдлээс хасагдахгүй зөвхөн үндсэн төлбөр хасагдаж, ашиглалтын зардал нэмэгдэн 2023 оны дамжуулан зээлийн өглөгийн үлдэгдэл 28,504,8 сая төгрөг болжээ.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын зөрчлийн нэгтгэлээр өр төлбөр данстай холбоотой 514.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Эдгээрийн зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

- Өв-Эко мийт ОНӨААТҮГ нь 513.6 сая төгрөгийн төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 242,872.7 сая төгрөг болж, өмнөх оноос 19,211.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо			/сая төгрөг/	
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт /+/-/Бууралт/-/	Хувь
Засгийн газрын оруулсан капитал	26,908.9	27,838.3	929.4	11.5
Өмч	12,029.5	12,029.5	-	5.0
Хуримтлагдсан үр дүн	162,350.5	180,632.1	18,281.6	74.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,365.2	22,365.2	-	9.2
Хяналтын бус хувь оролцоо	7.6	7.6	-	0.0
Дүн	223,661.7	242,872.7	19,211.0	100.0
Үнээс байгууллагын төрлөөр:				
Төсөвт байгууллага/ Төрийн сан	188,960.9	202,288.8	13,327.9	83.3
ОН-ын өмчт үйлдвэрийн газар	34,700.8	40,583.9	5,883.1	16.7
Дүн	223,661.7	242,872.7	19,211.0	100.0

Эх сурвалж: ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс нь үндсэн хөрөнгийн өсөлтийн 929.4 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн данс 18,281.6 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ. Тайлант онд дахин үнэлгэдсэн үндсэн хөрөнгө бүртгээгүй тул дахин үнэлгээний нөөц дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.9 Нэмэлт санхүүжилтийн данс

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 26 байгууллага 1,774.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 32 байгууллага 759.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 15 байгууллага 441.2 сая төгрөг, нийт 2,975.7 сая төгрөгийн орлогыг бурдуулжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 28 байгууллага 2,026.9 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 6 байгууллага 16.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 10 байгууллага 616.1 сая төгрөг, нийт 2,659.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 316.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Аудитын илрүүлэлт: Сум дундын ойн анги үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 64.2 сая төгрөгийн орлогыг төсөөт тодотгол хийлгүй шууд зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүн үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитор Ц.Мөнхзаяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/149 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 99,901.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 999.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

УИХ-аас төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн ба 2023 оны 6 дугаар сард хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 42.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 40.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ нь 2023 онд Шилэн дансны цахим хуудсанд 156 мэдээлэл оруулахаас 156 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүү-нийцлийн аудитыг хослуулан хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6,409.1 сая төгрөгийн 21 зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн. Сумдын ОНХСан, ХХСангууд шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллүүдээ дутуу байршуулсан нь нийт зөрчлийн 93 хувийг эзэлж байна.

4.4.2 Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан талаар

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 26.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 68 төсөл арга хэмжээг зохион байгуулжээ. Үүнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5, ОНХСангийн хөрөнгөөр 45, авто замын сангийн хөрөнгөөр 1, зорилтот жилийн санхүүжилтээр 3, зээл тусламжийн хөрөнгөөр 2, байгууллагын захиалгаар 12 төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөжээ. Дээрх худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [/tender.gov.mn/](http://tender.gov.mn/), “Өглөөний сонин” www.uvurkhangai.mn байгууллагын цахим сайт, <https://umch.ov.gov.mn/> сайтуудаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 68 төсөл арга хэмжээг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн шийдвэр гарсан өдрөөр цахим системд байршуулсан. Нийт төсөл арга хэмжээг босго үнээс нь хамааруулан нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу 24, тендер шалгаруулалтын онцгой журмаар 40, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтын журмаар 4 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу давхардсан тоогоор 489 аж ахуй нэгж өрсөлдөгч байгууллагынхаа материалтай танилцжээ.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүү-нийцлийн аудитыг хослуулан хийсэн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,365.9 сая төгрөгийн 5 зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.

4.5 Завсрлын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	6	237.20	6	237.2	100

Зөвлөмж	0	0	0	0	
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн яамны Э-тайланда авлага, өглөгийн насхилт болон тооцоо нийлсэн зэрэг ангиллыг үнэн зөв бүртгүүлж нэгтгүүлэхгүй байгаа тул дараагийн аудитаар анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 638.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Үүнд:

-Санхүүгийн байдлын тайланд Ахмадын сан нь 10.3 сая төгрөгийн аж ахуйн материалыа нөөцийн бараа дансанд бүртгэсэн байсныг аудитын явцад залруулсан.

-Нэгтгэсэн тайлангийн аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд Баруунбаян-Улаан, Баянгол сумдын ТТЗ, Богд, Уянга сумдын ЗДТГ, Аймгийн ИТХ, Аймгийн орон нутгийн өмчийн газар зэрэг байгууллагуудад 173.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалын дансаар салгаж бүртгээгүй байсныг аудитын явцад залруулж бүртгүүлсэн.

-“Хархорин-Ус суваг” ОНӨААТҮГ нь 442.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэсэн байсныг элэгдлийн зардал дансанд салгаж бүртгүүлсэн.

- “Баянтээг түлш” ОНӨҮГ нь эзэмших эрхтэй 31.7 сая төгрөгийн өртөг бүхий газраа Бусад биет бус хөрөнгө дансанд бүртгээгүй Газар дансанд тусдаа бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.

Аудитаар 4 зөрчил² илэрч, 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитын илрүүлэлт:

1.Өвөрхангай аймгийн Засаг даргын харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд тайлант онд үүссэн болон 5-аас бага жилийн насхилттай авлагын насхилтыг буруу бүртгэсэн, нягтлан бодогч нар э-тайланда авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байгаад хяналт тавиагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтуутай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Сангийн яамны Э-тайланда авлагын тодруулга тайланг буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж цаашид үнэн зөв бүртгэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг хүргүүлэв.

2.Баруунбаян-Улаан сумын ЗДТГ, ИТХ-ын нягтлан бодогч нь жирэмсний амралттай байх хугацаанд нягтлан бодогчийн ажлыг мэргэжлийн бус хүнээр гүйцэтгүүлж байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /марктан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бodoх бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодогчийн ажлыг мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Сум дундын ойн анги үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 64.2 сая төгрөгийн орлогыг төсөвт тодотгол хийлгүй шууд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих”, 37.1.8-д “Төсвийн сар, улирлын хуваарыт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй байх” заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагаа, нэмэлт орлого түүний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэх талаар

Аудитын илрүүлэлт:

Сумдын эрсдэлээс хамгаалах сангийн данснуудын нийт үлдэгдэл 623.3 сая төгрөг байгаа ба үлдэгдлийг сум тус бүрээр авч үзвэл, нийт 14 төрлийн жижиг сан, төсөл арга хэмжээний зориулалттай мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна. Эрсдэлээс хамгаалах сангаас зарцуулсан зардлууд нь Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, ОНХСангийн зарцуулалт, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалт, ГХУСАХ-ний зарцуулалтуудтай давхардаж байна. Мөн энэхүү мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг цаашид орон нутгийн тусгай сангийн үйл ажиллагааны зориулалтаар дангаар нь журамлан зарцуулах эрх зүйн үндэслэлгүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-т “гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах” Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, малын чанарыг сайжруулах, тэжээлийн нөөц бүрдүүлэх,..... зардалд зарцуулна: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан ОНХСангийн үйл ажиллагааны журмын 4.5.9 дэх заалт: ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журмын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэл болгон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг холбогдох дансанд хуваарилах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөөлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Өвөрхангай аймгийн төсвийн өрөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	ӨВА-2024/101/НА-СТА-ТШ3	Бат-Өлзий сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	1426.6	Дарга, нягтлан бодогч	
13	ӨВА-2024/66/НА-СТА-ТШ3	Нарийнтээл сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	657.3	Дарга, нягтлан бодогч	
14	ӨВА-2024/90/НА-СТА-ТШ3	Баянгол сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	102.4	Дарга, нягтлан бодогч	
15	ӨВА-2024/35/НА-СТА-ТШ3	Хужирт сумын ОНХсан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	1100.9	Дарга, нягтлан бодогч	
16	ӨВА-2024/82/НА-СТА-ТШ3	Бүрд сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	631.5	Дарга, нягтлан бодогч	
17	ӨВА-2024/54/НА-СТА-ТШ3	Төгрөг сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	334.4	Дарга, нягтлан бодогч	
18	ӨВА-2024/61/НА-СТА-ТШ3	Сант сумын ОНХСан	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй.	727.6	Дарга, нягтлан бодогч	
19	ӨВА-2024/40/НА-СТА-ТШ3	Хархорин сумын ОНХСан	ХАА-гаа зохион байгуулаагүй	197.9	Дарга, нягтлан бодогч	
20	ӨВА-2024/57/НА-СТА-ТШ3	Тараат сумын ОНХСан	ХАА-гаа зохион байгуулаагүй	40	Дарга, нягтлан бодогч	
			ХАА-гаа зохион байгуулаагүй	26	Дарга, нягтлан бодогч	
21	ӨВА-2024/50/НА-СТА-ТШ3	Уянга сумын ОНХсан	Зориулалт бус зарцуулсан	4.6	Дарга, нягтлан бодогч	
НИЙТ ДҮН				6340.2		
НИЙТ ДҮН				13301.2		